



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/95

Баян-Өндөр сум

Ээлжит бус хуралдаан  
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсгүүд, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг”-ийн 5.3, 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит бус V хуралдааныг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр танхим, цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл хангасугай. Үүнд:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох саналын тухай;
2. Мэдээлэл шуурхай удирдлагын төвийг татан буулгах тухай;
3. Ой тэмдэглэх ажлын хүрээнд авах зарим арга хэмжээний тухай;
4. Аймгийн баяр наадмын хороо байгуулах, зардлын задаргаа батлах тухай;
5. Эрдэнэт хотын болон аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай;
6. Аймгийн хэмжээнд төр хувийн хэвшлийн түншлэлээр хийх төслийн жагсаалт батлах тухай;
7. Орон нутгийн өмчийн 2024 оны дүн батлах тухай;
8. Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай;
9. Санал оруулах тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус V хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХБАТ

6125070270

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
даргын 2025 оны 06 дугаар сарын 17 өдрийн  
1/95 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ БУС V ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус V хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

VI/17-нд багтаан

Ажлын алба

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох саналын тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3. Мэдээлэл шуурхай удирдлагын төвийг татан буулгах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4. Ой тэмдэглэх ажлын хүрээнд авах зарим арга хэмжээний тухай асуудлын шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26-ны дотор Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ш.Ганболд

5. Аймгийн баяр наадмын хороо байгуулах, зардлын задаргаа батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

6. Эрдэнэт хотын болон аймгийн хөдөө аж ахуйн 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

7. Аймгийн хэмжээнд төр хувийн хэвшлийн түншлэлээр хийх төслийн жагсаалт батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах

шийдвэрийн төслийг хавсаргаж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

8.Орон нутгийн өмчийн 2024 оны дүн батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

9.Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

10.Санал оруулах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

VI/18, VI/23, VI/26 -ны дотор Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Ц.Оргилболд

11.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

VI/23-ны дотор Холбогдох Хороод

12.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

VI/26-ны дотор Ажлын албаны дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА